



**АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2026 оны 02-р сарын 12-ны өдөр

Дугаар 26/002

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2 дахь заалт, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь заалт, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.27, 7.31, “Айтүүлс ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 8 дугаар зүйлийн 8.1, 8.2 болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 02-р сарын 12-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн 2025 оны жилийн эцсийн цэвэр ашгийн 18.55 хувь буюу 137,808,496 (нэг зуун гучин долоон сая найман зуун найман мянга дөрвөн зуун ерэн зургаа) төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон хуваарилахаар шийдвэрлэсүгэй.
2. Нийт хувьцаа эзэмшигчдийн нэгж хувьцаанд тус бүр 4 (дөрөв) төгрөгийн ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр хуваарилж, холбогдох хууль тогтоомжийн дагуу хувь хүний болон аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг суутган тооцож, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХХК-аар дамжуулан 2026 оны 4 дугаар сарын 30-ны өдөр хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулсугай.
3. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрөөр тогтоосугай.
4. Ногдол ашиг хуваарилах шийдвэрийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулсугай.
5. Шийдвэртэй холбоотой мэдээллийг хууль, тогтоомжид заасан хугацаанд холбогдох байгууллага болон нийтэд мэдээлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (Г.Янжинлхам)-д даалгасугай.
6. Ногдол ашиг хуваарилах ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал (Ч.Мөнхжаргал)-д үүрэг болгосугай.
7. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн дарга (Г.Хатанболд)-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА

Г.ХАТАНБОЛД

